Хүүхэд өөрийгөө үнэлэх хөдөлмөрийн үнэлгээний монгол хувилбарын найдвартай, хүчин төгөлдөр байдлыг эрүүл хүүхдүүдэд судалсан нь

Г.Тунгалаг[1,2], М.Эрдэнэцэцэг[2], Б.Мөнх-Эрдэнэ[2]

[1]Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв
[2]АШУҮИС, Сувилахуйн сургууль, Бие Бялдар Судлалын тэнхим
Цахим шуудан: ot14d001@st.mnums.edu.mn, Утас: 80194996

Түлхүүр үг:
ХӨҮХҮ
Хөдөлмөрийн чадамж
Хөдөлмөр засал
Үнэт зүйл

Товч утга:

Үндэслэл: Хүүхэд өөрийгөө үнэлэх хөдөлмөрийн үнэлгээ (ХӨҮХҮ) нь өөрийн чадамж болон үнэт зүйлээ тодорхойлох боломжийг хүүхдэд олгодог ач холбогдолтой үнэлгээ болохыг судлаачид нотолсон байдаг. Энэ үнэлгээний монгол хувилбарын найдвартай хүчин төгөлдөр байдлыг эрүүл хүүхдүүд дээр судалсан судалгааны ажил манай улсад хийгдээгүй байна. **Зорилго:** Эрүүл хүүхдүүд хөдөлмөрийн чадамжаа өөрсдөө зөв үнэлэхийн тулд ХӨҮХҮ-ний монгол хувилбарыг найдвартай ашиглаж чадах эсэхийг тодорхойлох. **Арга, аргачлал:** Бид энэхүү судалгаандаа 2008-2013 оны хооронд төрсөн, 80 (эрэгтэй 47, эмэгтэй 33,) хүүхдийг хамруулсан бөгөөд судалгаанд хамрагдсан хүүхдийн дундаж нас нь 10.0± жил байв. Судалгааны тоон үзүүлтийг SPSS 23 программ ашиглан өгөгдөлд дүн шинжилгээ хийсэн. **Үр дүн:** ХӨҮХҮ-ний монгол хувилбарын хөдөлмөрийн чадамж хэсгийн Кронбах альфа коэффициент 0.939, үнэт зүйл хэсгийнх 0.954 буюу сайн, хэмжигч хооронд дотоод хүчин төгөлдөр байдал нь хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байсан. Хөдөлмөрийн чадамжийн асуултууд нь чадамжийн 12 асуулт, үнэт зүйлийн 9 асуулттай уялдаа хамааралтай байв ($r=0.640$, $P<0.05$). Харин үнэт зүйлийн асуултууд нь үнэт зүйлийн 10 асуулт, чадамжийн 10 асуулттай уялдаа хамааралтай байгаа нь тус тус тодорхойлогдлоо ($r=0.621$, $P<0.05$). **Дүгнэлт:** 1. Хүүхдүүд өөрсдийн хэрэгцээ болон санаа зовоосон, бэрхшээлтэй асуудлаа ХӨҮХҮ-ний хариулт байдлаар бусдад ойлгуулах боломжтой байгаа нь ажиглагдсан тул хөдөлмөр заслын практикт ХӨҮХҮ-г ашиглаж болохыг харуулж байна. 2. Энэ үнэлгээ нь өөрийн хөдөлмөрийн чадамжийн түвшин, чухалчилж үздэг үнэт зүйлс зэрэг хүүхэд өөртөө дүгнэлт хийж буй байдлыг илүү сайн мэдэх боломжийг хөдөлмөр засалч нарт олгож байна.

Үндэслэл: Хүүхэд өөрийгөө үнэлэх хөдөлмөрийн үнэлгээ (ХӨҮХҮ) нь өөртөө дүгнэлт хийх, төлөвлөх, танин мэдэхүйн чадвартай 8-13 насны хүүхдүүдэд тохирсон бөгөөд хүүхдүүдийн ойлгоц, өдөр тутмын үйл ажиллагаа хийх чадвар, тэдгээр үйл ажиллагаанд ач холбогдол өгөх, анхаарал хандуулах, асуудлыг тодорхойлох, тэдний зорилгод саад болж болзошгүй асуудлыг шийдвэрлэх зорилгоор боловсруулсан үйлчлүүлэгч төвтэй үнэлгээ юм. Энэ үнэлээг Голланд, Дани, Финллянд, Франц, Грек, Хебрю, Исланд, Итали, Словян, Перс, Испани зэрэг хэл рүү орчуулан найдвартай, хүчин төгөлдөр байдлыг судлан хөдөлмөр заслын эмчилгээнд ашиглаж байна[1,2,5,7-9].

Монгол улсын эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа хөдөлмөр засалч нар тухайн байгууллагынхаа эмчилгээний журамд нийцүүлэн үнэлгээний аргуудыг боловсруулж, орчуулан эмчилгээ үйлчилгээндээ ашигладаг. Эдгээр боловсруулсан үнэлгээнүүдийг ашиглахад хүүхэд өөрийнхөө хөдөлмөрийн чадамжийг тодорхойлох боломж хомс, мөн зохиогчийн эрхээр хүлээн зөвшөөрөгдөөгүй учир өнөөгийн хөдөлмөр заслын практикт найдвартай, хүчин төгөлдөр байдал нь нотолгоогоор батлагдсан үйлчлүүлэгч төвтэй, хөдөлмөрт суурилсан стандарт үнэлгээ дутагдаж

байна. Иймд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт хүүхдийн үнэлгээний талаар судалгааны ажил хийж монгол хувилбарыг боловсруулан гаргах шаардлагатай байна.

Зорилго: ХӨҮХҮ-ний монгол хувилбарыг эрүүл хүүхдүүд найдвартай ашиглаж чадах эсэхийг тодорхойлох.

Зорилт:

1. ХӨҮХҮ-ний англи хэл дээрх эх хувилбарыг монгол хэл рүү хөрвүүлж орчуулгын баталгаатай байдлыг шалгах
2. ХӨҮХҮ-ний монгол хувилбарын дотоод, гадаад, практик хүчин төгөлдөр байдлыг эрүүл хүүхдүүдийг үнэлэн тодорхойлох

Арга, аргачлал: Бид энэхүү судалгааг нэг агшингийн аргаар гүйцэтгэлээ. Судалгааг Нийслэлийн ерөнхий боловсролын 107 дугаар сургуульд суралцдаг 8-13 насны 80 хүүхдийг (эр 47, эм 33, дундаж нас 10.0 жил) хамруулж ХӨҮХҮ-ний монгол хувилбарыг хэрхэн ашиглах талаар ангийн багш нарт зааварчилгаа өгсөн. Энэхүү судалгааг хийж гүйцэтгэхдээ АШУҮИС-ийн Судалгааны Ёс зүйн Хяналтын хорооны 2021.06.18-ны өдрийн хурлаар (Дугаар 2021/3-08) хэлэлцүүлж, ёс зүйн зөвшөөрөл авч судалгааг түшиглэн явуулах байгууллага болон судалгаанд оролцогчдын эцэг эх, асран хамгаалагч нараас таниулсан зөвшөөрлийн хуудсаар зөвшөөрөл авсан.

Оролцогчдыг ХӨҮХҮ-ний монгол хувилбараар үнэлж, ХӨҮХҮ-ний бөглөсөн маягтуудыг Келлер ба Кийлхофнер (2005)-ын өгсөн удирдамжийн дагуу хөдөлмөрийн чадамж болон үнэт зүйлийн хариулт тус бүрийг 1-4 оноогоор тэмдэглэсэн[1,5]. Хөдөлмөрийн чадамжийг хэмжихдээ “Би энийг хийхэд маш их бэрхшээлтэй” гэсэн хариултад 1 оноо, “Би энийг хийхэд бага зэрэг бэрхшээлтэй” бол 2, “Би энийг хийж чаддаг” бол 3, “Би энийг үнэхээр сайн хийдэг” бол 4 гэж тус тус оноолсон. Үнэт зүйлийн хариултад “Надад тийм ч чухал биш” бол 1 оноо, “Надад чухал” бол 2, “Надад үнэхээр чухал” бол 3, “Надад хамгийн чухал” бол 4 оноо гэж тус тус тэмдэглэсэн. Үнэлгээний дотоод найдвартай байдлыг Кронбах альфа, үнэлгээний бүтцийн хүчин төгөлдөр байдлыг Спирман корреляци, чадамж болон үнэт зүйлийн ялгаа буюу практик хүчин төгөлдөр байдлыг асуулт бүрийн дундаж болон стандарт хазайлтыг тооцож тодорхойлсон.

Үр дүн: ХӨҮХҮ-ний монгол хувилбарын хөдөлмөрийн чадамж хэсгийн найдвартай байдлын Кронбах альфа коэффициент 0.939, үнэт зүйл хэсгийнх 0.954 байгаа нь тус үнэлгээний дотоод хүчин төгөлдөр байдал нь хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байгааг харуулж байна. Үнэлгээний бүтцийн хүчин төгөлдөр байдлыг шалгахын тулд хөдөлмөрийн чадамжийн асуултууд болон үнэт зүйлийн асуултуудын хоорондын хамаарлыг Спирман корреляцийн аргаар үзсэн. Хөдөлмөрийн чадамжийн асуултууд нь чадамжийн 12 асуултад, үнэт зүйлийн 9 асуултад уялдаа хамааралтай байв. Бусад бүх чадамжийн асуултууд нь чадамж болон үнэт зүйлийн асуултуудад уялдаа хамааралгүй байсан. Харин үнэт зүйлийн асуултын хувьд 10 асуулт нь үнэт зүйлийн асуултад, чадамжийн 10 асуултад уялдаа хамааралтай байсан бол бусад бүх үнэт зүйлийн асуултууд нь үнэт зүйл болон чадамжийн асуулттай уялдаа хамааралгүй байлаа. Судалгаанд оролцогчдын 7.35% нь “Би энийг хийхэд маш их бэрхшээлтэй”, 10.6 % нь “Би энийг хийхэд бага зэрэг бэрхшээлтэй”, 32.7% “Би энийг хийхдээ зүгээр”, 49.2% нь “Би энийг үнэхээр сайн хийдэг” гэсэн чадамжийн хариултуудыг сонгосон байв (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Үнэт зүйлсийн дундаж утга, стандарт хазайлт болон үнэлгээний хариултуудын давтамж

Асуултууд	Дундаж	Стандарт хазайлт	Үнэлгээний хариултуудын давтамж				
			Чухал биш	Чухал	Үнэхээр чухал	Хамгийн чухал	Алдаа
Гэр бүлтэйгээ ямар нэг зүйл хийх	3.36	.917	5	9	18	48	0
Биеэ цэвэр байлгах	3.33	.927	4	13	15	48	0
Хийж буй зүйлдээ анхаарах	3.31	.922	4	13	17	46	0
Ангийн дүрмийг дагах	3.27	.940	5	12	19	44	0
Өөрөө хувцаслах	3.25	.893	4	12	24	40	0
Найзуудтайгаа ямар нэг зүйл хийх	3.22	.940	5	13	21	41	0
Гэрийн даалгавраа хийж дуусгах	3.21	.937	5	13	22	40	0
Ангийхантайгаа ямар нэг зүйл хийх	3.20	.877	1	21	19	39	0
Хийхийг хүссэн зүйлээ сонгох	3.18	.901	3	17	22	38	0
Өөрийн эд зүйлээ арчлах	3.15	1.00	7	14	19	40	0
Ямар нэгэн зүйлийг өөрийн гараар хийдэг	3.12	.985	6	16	20	38	0
Хичээлээ цагт нь хийж дуусгах	3.10	.962	6	15	24	35	0
Асуудалтай тулгарсан үед арга зам бодох	3.05	.979	6	18	22	34	0
Амархан ядрахгүйгээр хийж байгаа зүйлээ дуусгадаг	3.03	1.04	7	21	14	38	0
Хийж байгаа зүйл хэцүү байсан ч хийсээр байх	3.01	.987	6	20	21	33	0
Бусдад санаагаа ойлгуулах	3.00	1.01	9	14	25	32	0
Хүссэн зүйлээ хийхэд зориулж биеэ хөдөлгөдөг	2.98	1.06	9	18	18	35	0
Гэрийн ажил хийх	2.97	1.03	9	16	23	32	0
Ямар ч тусламжгүй хооллох	2.96	1.06	11	13	24	32	0
Дуртай зүйлээ хийхдээ хангалттай цаг гаргадаг	2.93	1.02	8	20	21	31	0
Шаардлагатай үед багшаас асуулт асуух	2.91	.983	7	21	24	28	0
Сэтгэлээр унах үедээ өөрийгөө тайвшруулдаг	2.91	1.05	11	15	24	30	0
Хангалттай унтах	2.90	1.10	11	20	15	34	0
Нэг газраас нөгөө рүү шилжих, явах	2.76	1.16	15	20	14	31	0
Өөрөө ямар нэгэн зүйл худалдан авах	2.66	1.16	17	21	14	28	0

Тэмдэглэл: *Асуултуудыг хамгийн дээд дундажаас нь хамгийн бага дундаж хүртэлх дарааллаар жагсаав*

Харин үнэт зүйлийн хувьд 9.05% нь “Надад тийм ч чухал биш”, 20.2% “Надад чухал”, 24.9% “Надад үнэхээр чухал”, 45.7% “Надад хамгийн чухал” гэсэн хариултуудыг бөглөсөн байлаа (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Чадамжийн дундаж утга, стандарт хазайлт болон үнэлгээний хариултуудын давтамж

Асуултууд	Дундаж	Стандарт хазайлт	Үнэлгээний хариултуудын давтамж			
			Маш их бэрхшээлтэй	Бага зэрэг бэрхшээлтэй	Зүгээр	Үнэхээр сайн хийдэг
Ямар ч тусламжгүй хооллох	3.62	.700	3	1	19	57
Өөрөө хувцаслах	3.50	.763	4	1	26	49
Ангийн дүрмийг дагах	3.47	.762	3	4	25	48
Хийж буй зүйлдээ анхаарах	3.45	.793	3	6	23	48
Найзуудтайгаа ямар нэгзүйл хийх	3.37	.905	6	5	22	47
Биеэ цэвэр байлгах	3.36	.845	3	10	22	45
Гэрийн даалгавраа хийж дуусгах	3.35	.914	7	3	25	45
Хүссэн зүйлээ хийхэд зориулж биеэ хөдөлгөдөг	3.33	.885	5	7	24	44
Ямар нэгэн зүйлийг өөрийн гараар хийдэг	3.33	.841	5	4	30	41
Ангийхантайгаа ямар нэг зүйл хийх	3.31	.850	4	8	27	41
Хийхийг хүссэн зүйлээ сонгох	3.28	.814	4	6	33	37
Гэр бүлтэйгээ ямар нэг зүйл хийх	3.27	.899	7	3	31	39
Дуртай зүйлээ хийхдээ хангалттай цаг гаргадаг	3.23	.931	6	9	25	40
Өөрийн эд зүйлээ арчлах	3.23	.914	6	8	27	39
Хичээлээ цагт нь хийж дуусгах	3.21	.820	2	12	25	41
Хангалттай унтах	3.18	.994	8	9	23	40
Хийж байгаа зүйл хэцүү байсан ч хийсээр байх	3.18	.858	2	17	25	36
Гэрийн ажил хийх	3.15	.955	7	10	27	36
Асуудалтай тулгарсан үед арга зам бодох	3.11	.967	8	9	29	34
Шаардлагатай үед багшаас асуулт асуух	3.10	.908	6	11	32	31
Бусдад санаагаа ойлгуулах	3.06	1.02	11	`6	30	33
Амархан ядрахгүйгээр хийж байгаа зүйлээ дуусгадаг	2.97	1.05	10	15	22	33
Өөрөө ямар нэгэн зүйл худалдан авах	2.95	.990	10	12	32	26
Сэтгэлээр унах үедээ өөрийгөө тайвшруулдаг	2.90	.962	8	17	30	25
Нэг газраас нөгөө рүү шилжих, явах	2.87	1.05	10	20	20	30

Тэмдэглэл: *Асуултуудыг хамгийн дээд дундажаас нь хамгийн бага дундаж хүртэлх дараалаар жагсаав*

Хэлцэмж: Бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт үнэлгээ болох "Хүүхэд өөрийгөө үнэлэх хөдөлмөрийн үнэлгээ"-ний Монгол хувилбарыг бий болгож түүний хүчин төгөлдөр, баталгаатай, найдвартай байдлыг эрүүл хүүхдүүд дээр судласан бөгөөд бидний судалгаагаар тус үнэлгээг хөдөлмөр заслын эмчилгээнд ашиглахад үр дүнтэй гэсэн дүгнэлт гарсан.

Судлаач Romero-Ayuso D, судалгаанд үнэлгээний найдвартай байдлын Кронбах альфа коэффициент чадамж хэсгийнх 0.911 (p=0.05), үнэт зүйл хэсгийнх 0.922 (p=0.05) буюу хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байсан нь манай судалгааны дотоод хүчин төгөлдөр байдал нь хүлээн зөвшөөрөгдөх хэмжээний үр дүнтэй ижил байсан[6,7]. Мөн тус судалгаанд үйл ажиллагааны чадамжийн түвшин, үнэт зүйлийн зэргийг хөдөлмөр засалч нар мэдэж авснаар эмчилгээний төлөвлөгөө болон зорилго тодорхойлоход дөхөм гэж мэдээлсэн нь хүүхдийн хөдөлмөрийн чадамжийн түвшин, үнэт зүйлийн зэрэглэлийн талаарх хүүхдийн ойлголтыг илүү сайн мэдэх боломжийг хөдөлмөр засалч нарт харуулж байна гэсэн манай судалгааны үр дүнтэй тохирч байна[8,9].

Дүгнэлт:

1. ХӨҮХҮ-ний монгол хувилбарын хүчин төгөлдөр, найдвартай байдлыг баталж, хүүхэд бие даан хариулж болох үнэлгээний хомс байдлыг нөхөх боломж өглөө.
2. Хөдөлмөр засалчид тус үнэлгээг ашиглаж хүүхдийн хөдөлмөрийн чадамжийн түвшин, чухалчилж үздэг үнэт зүйлс, хүүхдийн ойлголт зэргийг үнэлж, эмчилгээний төлөвлөгөө болон зорилго тодорхойлохдоо ашиглахад боломжтой байна.

Ном зүй:

1. *Keller J, Kafles A, Basu S, Federico J, Kielhofner G:Child Occupational Self-Assessment Version 2.2. Chicago.MOHO Clearinghouse, Department of Occupational Therapy,College of Applied Health Sciences,University of Illinois at Chicago. 2006.*

2. Kielhofner G. A Model of Human Occupation:Theory and application(4th ed.), 2008, pp 143-154
3. KellerJ, Kafkes A, Kielhofner G:Psychometric characteristics of the Child Occupational Self-Assessment (COSA), part one: An initial examination of psychometric properties.Scandinavian Journal of Occupational Therapy .12(3), 2005,118-127.
4. Keller J, Kielhofner G: Psychometric characteristics of the Child Occupational Self-Assessment (COSA), part two : Refining the psychometric properties. Scandinavian Journal of Occupational Therapy,12(4), 2008,147-158.
5. Ayuso DMR, Kramer J: Using the Spanish Child Occupational Self-Assessment (COSA) With Children With ADHD. Occupational Therapy in Mental Health. 25(2), 2009, 101-114.
6. Hoza B,Gerdes AC, Hinshaw SP,Arnold LE,Pelham WEJR,Molina BS, Odbert: Self-perceptions of competence in children with ADHD and comparison children. Journal of Consulting and Clinical Psychology.72(3), 2004, 382.
7. Sattari M, Yazdani F, Rassafiani M, and Hosseini S: Construct validity of the Persian version of the Child Occupational Self-Assessment in children with attention- deficit/hyperactivity disorder in Iran . Hong Kong Journal of Occupational Therapy. 32(2), 2019,127-135.
8. Kramer JM, Kielhofner G, Smith.E.V.JR: Validity Evidence for the Child Occupational Self-Assessment. American Journal of Occupational Therapy. 64(4), 2010,621-631
9. Velden M, Couldrick L, Kinebanian A, Sadlo G: Dutch Children's Perspectives on the constructs of the Child Occupational Self-Assessment(COSA). Occupation, Participation and Health. 33(1), 2013, 50-58.

Studying the reliability and validity of the Mongolian version of the Child Occupational Self-Assessment in healthy children

Tungalag G[1,2], Erdenetsetseg M[2], Munkh-Erdene B[2]

[1]Rehabilitation development center for children with disabilities
[2]Department of Physical,Occupational Therapy, Nursing School of MNUMS
E-mail: ot14d001@st.mnums.edu.mn, Tel: +976-80194996

Background: Child Occupational Self-Assessment (COSA) allows children to assess their own abilities and values. The reliability and validity of the Mongolian version of this assessment needs to be investigated in healthy children.
Aim: The purpose is to determine whether healthy children can reliably use the Mongolian version of COSA to correctly assess their occupational competencies.
Material and Methods: A total of 80 children (male 47, female 33, mean 10.0) born in 2008-2013. The data were analyzed using SPSS 23 software.
Results: The internal validity between the scales was acceptable, as the Cronbach's alpha coefficient of the part of occupational competence was 0.939, of values scale was 0.954. Occupational competence items were correlated with 12 items of competence and 9 items of values ($r=0.640$, $P<0.05$). As for items of values, 10 items were correlated with items of values and 10 items of competence ($r=0.621$, $P<0.05$). To the competence items 7.35% of the participants of this study gave answers "I have a big problem doing this ", 10.6% "I have a big problem doing this ", 32.7% "I do this ok ", and 49.2% "I am really good at doing this" (Table 1). As for values items, 9.05% answered "Not really important to me", 20.2% "Important to me", 24.9% "Really important to me", and 45.7% "Most important of all to me".
Conclusion: The results of the study indicate that the responses to the COSA also indicate that children can use the COSA to explain their own needs, concerns, and difficulties to others. Therefore, this assessment allows occupational therapists to better understand the child's self-evaluations, such as the level of occupational competencies and the values.

Keywords: COSA, Occupational competence, Values, Occupational therapy